

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

*/2021 оны жилийн эцсийн байдлаар/*

№	д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Хэм жих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	Хариуцах нэгж
<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛГО: “АГААРЫН ТЭЭВРИЙН ЛИБЕРАЛЧЛАЛЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ, ӨРСӨЛДӨӨНИЙГ БИЙ БОЛГОЖ, НИСЛЭГИЙН ТОО, ЧИГЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭН, ОРОН НУТГИЙН НИСЭХ БУУДЛУУДЫН АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛНА”</b>										
<b>Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ</b>										
	<b>1</b>	<b>Зорилт 1 Улс хооронд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх</b>	<b>-</b>	<b>Өөрчлөлт оруулсан хэлэлцээрийн тоо Үзэглэсэн хэлэлцээрийн тоо</b>	<b>Тоо</b>	<b>0</b>	<b>Эхний хагас жилд: -  Жилийн эцэст: 2 2</b>	<b>Үзэглэсэн хэлэлцээр-1 Чиглэл, давтамж нэмэгдсэн хэлэлцээрийн тоо-1</b>		
1	1.1.	Бүгд Найрамдах Азербайжан Улстай тохирч үзэглэсэн Агаарын харилцааны хэлэлцээрийг эцэслэн байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Хэлэлцээр эцэслэн байгуулахаар оролцогч талуудтай харилцаж, хэлэлцээр байгуулах товыг тохирсон эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Жилийн эцэст:1</b>	<b>Азербайжаны</b> талтай үзэглэсэн “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийг байгуулах бэлтгэл ажил хангагдсан боловч хэлэлцээрт гарын үсэг зурах ажил цар тахлын улмаас хойшлогдсон. Иймд хэлэлцээрийг дипломат шугамаар ноот бичиг солилцож байгуулах саналыг Азербайжаны талд ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. Азербайжаны талаас 2018 онд үзэглэсэн хэлэлцээрийн төсөлд өөрчлөлт оруулах талаар ЗТХЯ-наас 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 09/3487 тоот албан бичгээр мэдэгдсэн бөгөөд холбогдох өөрчлөлтийг оруулж, 2021 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 01/1364 тоот албан бичгээр	100%	АТБЗГ

								ЗТХЯ-нд хүргүүлсэн. Азербайжаны талтай цар тахлын нөхцөл байдал намжсаны дараа өндөр хэмжээний айлчлалын үеэр 2018 онд үзэглэсэн хэлэлцээрийг эцэслэн байгуулахаар тохирсон.		
2	1.2.	Грек Улстай тохирч үзэглэсэн Агаарын харилцааны хэлэлцээрийг эцэслэн байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Хэлэлцээр эцэслэн байгуулахаар оролцогч талуудтай харилцаж, хэлэлцээр байгуулах товыг тохирсон эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Жилийн эцэст:1</b>	<b>Грекийн</b> талтай үзэглэсэн “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийг байгуулах бэлтгэл ажил хангагдсан боловч хэлэлцээрт гарын үсэг зурах ажил цар тахлын улмаас хойшлогдсон. Иймд хэлэлцээрийг дипломат шугамаар ноот бичиг солилцож байгуулах саналыг Грекийн талд ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. Грекийн талаас хариу ирүүлээгүйтэй холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр АХХ эцэслэн байгуулах ажлыг дипломат шугамаар гүйцэтгэх саналаа Грекийн талд хүргүүлсэн. БНХАУ-д суугаа 2 улсын сайд хэлэлцээрийг баталгаажуулах боломжтой гэсэн хариуг Грекийн талаас 2021 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Е-мэйл ирүүлсэн. Түүний дагуу хэлэлцээрийн төслийг монгол, грек, англи 3 хэл дээр бэлтгэж, БНХАУ-д суугаа хоёр улсын элчин сайдуудаар албажуулан хэлэлцээрт гарын үсэг зурахаар ГХЯ-тай хамтран ажиллаж байна.	90%	АТБЗГ

3	1.3.	Испани Улстай тохиролцсон агаарын харилцааны хэлэлцээрийг үзэглэнэ.	-	Үзэглэсэн хэлэлцээрийн тоо	Тоо	0	<b>Эхний хагас жилд:</b> Оролцогч талтай харилцаж, хэлэлцээрийн төслийг урьдчилсан байдлаар тохирсон байна. <b>Жилийн эцэст:1</b>	Испанийн Вант Улстай байгуулах “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-ийн төслийг эцэслэн тохиролцож, 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр үзэглэсэн.	100%	АТБЗГ
4	1.4.	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улстай тохирсон Агаарын харилцааны хэлэлцээрийг үзэглэнэ.	-	Үзэглэсэн хэлэлцээрийн тоо	Тоо	0	<b>Эхний хагас жилд:</b> Оролцогч талтай харилцаж, хэлэлцээрийн төслийг урьдчилсан байдлаар тохирсон байна. <b>Жилийн эцэст:1</b>	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улстай “Агаарын харилцааны тухай хэлэлцээр” байгуулах асуудлаар 2018 оноос хойш Лаосын талтай хэлэлцэж байгаа бөгөөд Лаосын тал хойшлуулсаар байна. Хэлэлцээр үзэглэх тухай саналаа 2020.07.20-ны өдөр хүргүүлж, 2020 оны 10 эсхүл 11 дүгээр сард цахимаар уулзалт хийхээр товлосон боловч Лаосын талаас тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. 2021 онд 5 удаа /2021.06.03, 2021.07.21, 2021.07.30, 2021.11.08, 2021.12.02/ хэлэлцээрийн төслийг Лаосын талд хүргүүлж, АХХ-ийн төслийг цахимаар уулзалт хийж тохирох санал тавьсан. Лаосын талаас хойшлуулсан.	50%	АТБЗГ
5	1.5	АНУ-тай “Нээлттэй агаарын зайн хэлэлцээр” байгуулах бэлтгэл ажлыг хангана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Хувь	0	<b>Эхний хагас жилд:</b> Бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг	ИНЕГ-ын даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд шууд нислэг	100%	АТБЗГ

						<p>батлан, хэрэгжилтийг эхлүүлсэн байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> 60%</p>	<p>эхлүүлэхтэй холбоотойгоор АНУ-ын Төрийн департамент, Холбооны нисэхийн захиргаа, Тээврийн яам, Тээврийн аюулгүй байдлын агентлагийн төлөөлөлтэй хамтран Агаарын харилцаа, эдийн засгийн зохицуулалт бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг, Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалтад хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг, Нисэхийн аюулгүй байдлын үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг тус тус байгуулсан. Агаарын харилцааны хэлэлцээг эхлүүлэхтэй холбоотойгоор ажлын хэсгийг ЗТХЯ-ны дэргэд Гадаад харилцааны яамыг оролцуулан байгуулах тухай хүсэлтийг ажлын хэсгийн удирдамжийн хамт 2021 оны 3 дугаар сарын 25-ны 01/506 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Агаарын харилцаа, эдийн засгийн зохицуулалт бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдөр ажлын хэсгийн дарга баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 2021 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 94%-тай. Төлөвлөгөөний дагуу Агаарын харилцааны хэлэлцээрийн төслийн албан ёсны орчуулгыг хийж</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--

								гүйцэтгэсэн. Мөн АНУ-аас бусад улстай байгуулсан хоёр талт хэлэлцээрүүдийг харьцуулах судалгаа шинжилгээ хийж байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар АНУ-ын талтай Агаарын харилцааны хэлэлцээ хийх ажлын хэсгийг байгуулсан. АНУ-руу нислэг гүйцэтгэхээр төлөвлөж буй "МИАТ" ХК, ИНЕГ-ын АТБЗГ, НААХЗА хамтарсан танилцуулга хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулсан. Агаарын харилцааны хэлэлцээр байгуулахтай холбогдуулан АНУ-ын Элчин сайдын яамны төлөөлөгчидтэй хамтын ажиллагааны уулзалтуудыг 2021 оны 2-р сарын 25-ны өдөр, 2021 оны 8 дугаар сарын 25, 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсан.		
6	1.6	Япон Улстай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт нислэгийн давтамж нэмэх зохицуулалтыг оруулна.	-	Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд:</b> Оролцогч талтай харилцаж, хэлэлцээрийн төслийг урьдчилсан байдлаар тохирсон байна.  <b>Жилийн эцэст:</b> 1	ЗТХЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу Япон Улсын Иргэний нисэхийн товчоотой хоёр улсын хооронд долоо хоногийн нислэгийн давтамжийг 30 болгохоор 2021 оны 4 дүгээр сарын 29-ний болон 5 дугаар сарын 20-ны өдөр тохирч Санамж бичгийн төслийг Японы талтай хамтран боловсруулсан. ЗТХЯ-ны 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 09/3697, 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн	70%	АТБЗГ

								09/4874 тоот албан бичгүүдээр давтамж, багтаамжийг уялдуулах чиглэл өгсний дагуу Японы талтай дахин хэлэлцээ хийж санал солилцож байна. Японы талаас 2021 оны 11 дүгээр сарын 12 болон 12 дугаар сарын 2-ны өдөр дотоодын агаарын тээвэрлэгчдээсээ санал авч байгаа тул ойрын хугацаанд хариу өгөхөө мэдэгдээд байна.		
7	1.7	ОХУ-ын талтай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт өөрчлөлт оруулах, нислэгийн цэг нэмэх талаар хэлэлцээ хийнэ.	-	Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд:</b> Оролцогч талтай харилцаж, хэлэлцээрийн төслийг урьдчилсан байдлаар тохирсон байна. <b>Жилийн эцэст:</b> 1	ОХУ-ын Тээврийн яамтай харилцан санал солилцож, ОХУ-ын Кызыл, Монголын Улаангом хотыг нисэн очих цэгээр нэмж, нислэгийн чиглэл нэмсэн.	100%	АТБЗГ
8	1.8	Индонези, Малайз Улсуудтай аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалт бүрдүүлнэ.	-	Аяллын дугаар хамтран ашиглах тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд:</b> Оролцогч талтай төслийг солилцсон байна. <b>Жилийн эцэст:</b> 2	Бүгд Найрамдах Индонези Улс, Бүгд Найрамдах Малайз Улсын Иргэний нисэхийн байгууллагуудтай хоёр улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчид аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалт тохирох тухай санал, Санамж бичгийн төслийн хамт 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/11 тоот албан бичгээр тус улсуудад хүргүүлсэн. Малайзын талаас 5 дугаар сарын 20-ны өдөр хариу төсөл ирүүлсэн бөгөөд уг төсөлд агаарын тээврийн 3, 4	70%	АТБЗГ

								<p>дүгээр эрхийг аливаа хязгаарлалтгүйгээр эдлэх тухай санал ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан Монголын талаас 1997 онд байгуулсан АХХ, нислэгийн зохицуулалт 2021 он хүртэл хэрэгжээгүйтэй холбогдуулан эхний ээлжинд зөвхөн аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалт тохирох саналаа 5 дугаар сарын 28-ны өдөр дахин хүргүүлсэн. Малайзын талаас хариу ирүүлээгүй тул ИНЕГ-аас 2021 оны 10 дугаар сарын 4, 2021 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Малайзын талд аяллын дугаар хамтран ашиглах зохицуулалтаа яаралтай тохирох хариу өгөхөө мэдэгдсэн.</p> <p>Индонезийн талаас Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээр байгуулах саналыг 2021 оны 8 дугаар сарын 6-ны өдөр ирүүлсэн. Монголын талын АХХ-ийн төслийг 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Индонезийн талд хүргүүлсэн.</p> <p>Индонезийн талаас АХХ-ийн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн бөгөөд талууд АХХ төсөл тохиролцохоор хамтран ажиллаж байна.</p>		
	2.	<b>Зорилт 2</b> <b>2020 онд 75%-тай байсан “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний</b>		<b>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний</b>	<b>Хувь</b>	<b>75%</b>	<b>Эхний хагас жилд:-</b> <b>Жилийн эцэст: 80%</b>	<b>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-59,6%</b>		

		хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021 онд 80%-д хүргэх		хэрэгжилт, хувиар				ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоол уг хөтөлбөр хүчингүй болсон тул хөтөлбөрийн хэрэгжилтийг зогсоосон.		
9	2.1.	Алслагдсан бүс нутгийн иргэдэд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлнэ.		Зорчигчийн тоо  Тийзийн үнийн бууралт	Тоо  Хувь	0	<b>Жилийн эцэст:</b> 2500  50%	Улаанбаатар-Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 16 удаагийн нислэгээр 878 зорчигч, 55%-ийн дундаж суудал ашиглалттайгаар, 50%-ийн хямдралтай үнээр тээвэрлэсэн байна. "Геосан" ХХК 2021 оны 10 дугаар сарын 02-ны өдөр гүйцэтгэгчээр шалгарч, Улаанбаатар-Тосонцэнгэл-Улаанбаатар, Улаанбаатар-Баруун-Урт-Улаанбаатар чиглэлд тус бүр 14 удаа нислэг гүйцэтгэхээр гэрээ байгуулах шатанд байсан боловч ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор уг хөтөлбөр хүчингүй болсон тул энэ ажлыг зогсоосон.	70%	АТБЗГ
10	2.2.	2020 онд 1 байсан нөхөн олговортой нислэгийг 2021 онд 3-аар өсгөнө.	1,000.0	Нөхөн олговортой нислэгийн тоо	Тоо	1	<b>Эхний хагас жилд:</b> 1  <b>Жилийн эцэст:</b> 2	Улаанбаатар-Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 16 удаагийн нислэгээр 878 зорчигч, 55%-ийн дундаж суудал ашиглалттайгаар, 50%-ийн хямдралтай үнээр тээвэрлэсэн байна. "Геосан" ХХК 2021 оны 10 дугаар сарын 02-ны өдөр гүйцэтгэгчээр шалгарч, Улаанбаатар-Тосонцэнгэл-Улаанбаатар, Улаанбаатар-Баруун-Урт-Улаанбаатар	70%	АТБЗГ



								чиглэлд тус бүр 14 удаа нислэг гүйцэтгэхээр гэрээ байгуулах шатанд байсан боловч ЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор уг хөтөлбөр хүчингүй болсон тул энэ ажлыг зогсоосон.		
	3.	<b>Зорилт 3 Орон нутгийн 3 нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох</b>		<b>4С нисэх буудал болгох ажлын үе шат</b>	<b>Үе шат</b>	<b>1</b>	<b>Эхний хагас жилд:-  Жилийн эцэст: 2</b>			
11	3.1.	Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.		Санхүүжилтийг шийдвэрлүүлэх-ээр холбогдох арга хэмжээг авсан эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Жилийн эцэст: 1</b>	Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлын хөөрч буух зурвасыг шинээр барихад 50.7 тэрбум төгрөг, зорчигч үйлчилгээний барилгыг цагт 300 зорчигч хүлээн авах боломжтой болгож өргөтгөхөд 4.6 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд санхүүжилтийг эрэлхийлсэн. Энэ төслийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлд хамруулах хүсэлтээ ЗТХЯ-наас 2021.02.06-ны өдрийн 01/84 тоот албан бичгээр АХБ-нд хүргүүлсэн. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Чойбалсан нисэх буудлыг 4С оруулахаар саналаа 2021.05.10-ны өдрийн 01/599 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн яамнаас хассан. Мөн төслийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төрийн өмчийн	90%	АННББЗГ ИНУТ СХОГ

								<p>концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөлтэй 2021.07.28-ны өдөр онлайнаар уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан. Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс өрийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн.</p>		
12	3.2.	Ховд аймгийн “Ховд” нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.		Санхүүжилтийг шийдвэрлүүлэх-ээр холбогдох арга хэмжээг авсан эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Жилийн эцэст: 1</b>	Ховд аймгийн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөх, хүчитгэхэд 28.3 тэрбум төгрөг, цагт 300 зорчигч хүлээн авах зорчигч үйлчилгээний	90%	АННББЗГ ИНУТ СХОГ

							<p>цогцолборыг шинээр барихад 21.6 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд санхүүжилтийг эрэлхийлж байна. Төслийг зээл тусламж, концессын аль боломжит байдлаар хэрэгжүүлэхээр <b>санхүүжилтийг эрэлхийлсэн.</b> Төслийн санхүүжилтийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлүүлэх хүсэлтийг ЗТХЯ-ны 2021 оны 01/732 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн тус төслийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Ховд аймаг дахь нисэх буудлыг 4С болгох төсөл, арга хэмжээг тусгуулахаар саналаа 2021.05.10-ны өдрийн 01/699 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн яам хассан. АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөхтэй 2021.07.28-ны өдөр онлайнаар уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан.</p>	
--	--	--	--	--	--	--	---	--

								Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс ерийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн.		
13	3.3.	Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг Олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ.	77.4	Санхүүжилтийг шийдвэрлүүлэх-ээр холбогдох арга хэмжээг авсан эсэх  Зураг, төсвийн тоо	Тийм-1 Үгүй-0  Тоо	0	<b>Жилийн эцэст:</b> 1  1	“Дэглий цагаан” нисэх буудлын хөөрч буух зурвасыг 451м-ээр уртасгаж өргөтгөх, хүчитгэхэд 61.1 тэрбум төгрөг шаардлагатай. Тус төслийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. “Дэглий цагаан” нисэх буудлын Зорчигч үйлчилгээний цогцолборын өргөтгөлийн ажлын зураг төслийг хүлээн авч, Барилгын хөгжлийн төвөөр хянуулахаар	70%	АННББЗГ ИНУТ СХОГ

								<p>2021.04.08-ны өдөр хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад “Дэглий цагаан” нисэх нисэх буудлын хөөрч буух зурвасыг 451м-ээр уртасгаж өргөтгөх, хүчитгэх ажлыг тусгуулахаар саналаа 2021.05.10-ны өдрийн 01/699 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч 2022 оны төсөвт холбогдох зардлыг Сангийн яам хассан. Увс аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигч хүлээн авах хүчин чадалтай болгон өргөтгөх зураг төслийг боловсруулах гүйцэтгэгчээр “Нэйкстслеп констрашн” ХХК 2020.10-р сард шалгарч, зураг төсвийг боловсруулж, энэ оны 4 дүгээр сарын 19-нд Барилгын хөгжлийн төвд хянуулахаар хүргүүлсэн боловч буцаагдсан. Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын зураг төслийг яаралтай батлуулах арга хэмжээ авч, явцыг энэ оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн дотор мэдээлэх үүрэг даалгаврын дагуу ИНҮТ-ийн Дэд дарга гүйцэтгэгч компанитай 2021.10.03-нд уулзаж, зураг төслийг энэ оны 12 дугаар сард багтаан батлуулах арга хэмжээ авахыг үүрэг болгосон.</p>		
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

								Төслийг зээл тусламж, концессын аль боломжит байдлаар хэрэгжүүлэхээр <b>санхүүжилтийг эрэлхийлж байна.</b> АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөхтэй 2021.07.28-ны өдөр онлайнаар уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан. Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс өрийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн.		
4.	Зорилт 4 Орон нутгийн нисэх буудлуудын нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах		DOC 9157 part 2-ын шаардлагыг хангуулсан эсэх  Цагт 50 зорчигч хүлээн авах	Тийм-1 Үгүй-0	0	Эхний хагас жилд:-  Жилийн эцэст: 1 1				

				хүчин чадалтай болсон эсэх						
14	4.1.	Баянхонгор аймаг дахь нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засварыг хийнэ.	992.3	Засварын ажлын гүйцэтгэл, хувиар	Хувь	0	<b>Жилийн эцэст:</b> 100%	Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын их засварын ажлын гүйцэтгэгчээр “Энигма констракшн” ХХК шалгарч, Иргэний нисэхийн ерөнхий газартай Ажил гүйцэтгэх тухай ИНЕГ/ХО/ТББ/Б-07/20-52/20 дугаартай гэрээг 2020 онд байгуулсан. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021.07.08-ны өдрийн А/255 дугаар тушаалаар “Энигма констракшн” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх ажлын хэсгийг байгуулж, талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр 2021.08.16-ны өдөр нэмэлт гэрээ байгуулсан. Гэрээнд тусгасан нэмэлт өөрчлөлтийн дагуу гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоногийн дотор ажлыг эхлүүлж, 30 хоногт багтаан барилгын ажлыг дуусгаж, хүлээлгэж өгөхөөр байсан боловч гэрээний үүргээ биелээгүй тул гэрээ цуцлах хүсэлтээ ИНҮТ-ийн даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 10-1/1526 тоот албан бичгээр “Энигма констракшн” ХХК-д хүргүүлсэн. Мөн гүйцэтгэлийн баталгаа,	0%	ИНҮТ

								урьдчилгаа төлбөрийн баталгааг цуцалж, мөнгөн төлбөрийг захиалагчийн дансанд төвлөрүүлэх тухай мэдэгдлийг Капитрон банкинд 2021.10.27-ны өдөр хүргүүлсэн. 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг ажлыг тусгахаар ажиллаж байна.		
15	4.2.	Хэнтий аймаг дахь “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлэхэд хяналт тавина.		Аэродромын барилга угсралтын ажлын гүйцэтгэл, хувиар  Барилга угсралтын ажлын гүйцэтгэл, хувиар	Хувь	52%;  0%	<b>Жилийн эцэст:</b> Аэродромын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 100%,  Зорчигч үйлчилгээний барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30%.	Аэродромын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2021.10.15-ны өдрийн байдлаар 70%-тай байна. ИНҮТ-ийн даргын 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Б/230 дугаар тушаалаар Буянт-Ухаа ОУНБ-ын аэродромын инженер Б.Шижир-Эрдэнийг хяналтын инженерээр томилсон бөгөөд хяналтын инженер нь гэрээний хугацаанд аэродромын стандарт, дүрэм, журам болон зураг төслийг төсвийн дагуу гүйцэтгэж байгаа байдалд өдөр тутмын технологийн хяналт тавьж ажилласан. Барилгын гүйцэтгэлийн явцын тайланг 7 хоног бүр хяналтын инженерээр гаргуулж, хянаж ЗТХЯ-нд цахимаар хүргүүлж байв. Гүйцэтгэгч WXP ХХК нь гэрээний дагуу 2021.03.21-ний өдөр барилга угсралтын ажлыг эхлүүлэх байсан боловч цар тахлын улмаас 3 сар хоцорч ажлаа 2021.06.21-нд эхлүүлсэн. ЗТХ-ийн сайдаас 2021 оны 8 дугаар сард 1 сарын хугацаатай ажил	50%	АННББЗГ



								эрчимжүүлэх үүрэг даалгавар өгч ажилласны үр дүнд эхлээгүй байсан перрон байгуулах, гэрэл суултын систем, хашааг шилжүүлэх болон үерийн хамгаалалтын ажлуудыг гүйцэтгэсэн. ИНЕГ-ын АННББЗГ нь Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл” Багц-2 Аэродромын барилга угсралтын ажлын явцтай 2020 онд 2 удаа, 2021 онд 5 удаа газар дээр нь танилцаж, ажлын явцыг эрчимжүүлэх талаар үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж байсан. “Өндөрхаан” нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Багц-1 тендерийн асуудлаар “Хар чонот” ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийг эцэслэн шийдвэрлэсэн Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн 2021 оны 126 дугаар тогтоол гарсан. 2021.10.20-ны өдөр ЗТХЯ, Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төслийн нэгж, ИНУТ-ийн хамтарсан уулзалт зохион байгуулж, багц 2 “Аэродромын барилга угсралтын ажил”-ын гэрээг 2022 оны 7 дугаар сар хүртэл сунгахаар шийдвэрлэсэн.		
16	4.3.	Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог нисэх	5,000.00	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	Хувь	0	<b>Жилийн эцэст:</b> 80%	Гүйцэтгэгчээр шалгарсан “Биг монголиа билдинг” ХХК Зам, тээврийн хөгжлийн яамтай	30%	АННББЗГ

		буудлыг зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барьж, байгуулахад хяналт тавина.						<p>2020.06.19-ний өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу ажлаа 2021.08.01-нд хүлээлгэн өгөх байсан боловч, зураг төсөл бэлэн болоогүй байсан тул ажлыг 2021.03.26-нд эхлүүлсэн.</p> <p>Барилгын гүйцэтгэлд хяналт тавих хяналтын инженерээр ИНУТ-ийн гэрээт ажилтан Х.Аманжолыг томилсон ба 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн барилга угсралтын ажлын явцад байнгын хяналт тавьж, гарсан зөрчил дутагдлыг залруулах арга хэмжээг авч ажилласан. Ажлын гүйцэтгэлийн тайланг ЗТХЯ-ны ИНБХЗГ-т 7 хоног бүр цахимаар хүргүүлж байв. Мөн ЗТХС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Төслийн менежер томилох тухай” А/06 дугаар тушаалаар АННББЗГ-ын дарга Д.Эрдэнэбаатарыг төслийн менежерээр томилсон ба барилгын ажлын гүйцэтгэлийн явцтай газар дээр нь танилцаж, гүйцэтгэлийг 3 удаа хянан баталгаажуулж, Улсын төсөвт тусгагдсан санхүүжилтээс 1,030,724,182 төгрөгийн санхүүжилт олгуулсан. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 7 дугаар сарын 29-ний</p>	
--	--	---	--	--	--	--	--	---	--

							<p>өдрийн А/87 дугаар тушаалаар гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсэг байгуулагдан дүгнэлт гаргасан. Тус дүгнэлтийн дагуу нэмэлт гэрээ байгуулж, 2021.12.10-ны өдөр хүртэл гэрээний хугацааг сунгасан. Гэвч “Биг Монголиа Билдинг” ХХК нь 2021.09.14-ний 242/21 тоотор төсвийн зөрүүтэй байдлаас шалтгаалан санхүүгийн хүндрэлд орсон учир барилга угсралтын ажлыг 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр зогсоосон. Тус газраас төсвийн зөрүүтэй байдлыг хэрхэн шийдвэрлэх талаар Ерөнхий сайдын зөвлөх, Зам, тээврийн хөгжлийн яам, “Биг Монголиа Билдинг” ХХК-ийн төлөөлөгчдийг оролцуулан нийт 5 удаагийн хурал уулзалтыг зохион байгуулсан. Хурлаар харилцан тохирсны дагуу ЗТХЯ-ны 2021.09.27-ны 01/4247 тоот албан бичгээр тус зорчигч үйлчилгээний барилгын ажлыг зам, тээврийн салбарт хэрэгжиж буй барилгын үнийн индекстэй уялдуулан төсвийн нэмэгдэл олгох жагсаалтад хамруулж өгөх, барилгын ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг тооцон олгох, барилгын ажлын төсөвт өөрчлөлт оруулах, дутуу санхүүжилтийг нөхөн олгуулах тухай хүсэлтийг</p>	
--	--	--	--	--	--	--	---	--

								Сангийн сайдад уламжилсны үр дүнд Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Монгол улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XV.3.1.1 –д “Дэлүүн болдог нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум” төсөвт өртөг 8,4 тэрбум төгрөг, 2022 онд санхүүжих дүн 4,4 тэрбум төгрөгөөр тусгагдсан байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2021.10.15-ны өдрийн байдлаар 21.5%-тай.		
	5.	<b>Зорилт 5 Нисэх буудлуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</b>		<b>Ашиглалтад орсон олон улсын нисэх буудлын тоо Бодлого, төлөвлөлттэй болсон эсэх</b>	<b>Тоо  Тийм-1 Үгүй-0</b>	<b>0</b>	<b>Жилийн эцэст: 1 1</b>	<b>Ашиглалтад орсон олон улсын нисэх буудлын тоо-1 Бодлогын төсөл боловсруулсан.</b>		
17	5.1.	Улаанбаатар хотын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлж, байнгын ашиглалтад оруулна.		ИНД139 шаардлагын дагуу аэродромыг гэрчилгээжүүлэх үзлэг шалгалт хийсэн эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд: 1</b>	Тус нисэх буудлыг ИНД-139 дагуу энэ оны 6 дугаар сарын 24-нд гэрчилгээжүүлсэн.	100%	НААХЗА
18	5.2.	Нисэх буудлуудыг 2030 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан, батална.		Батлагдсан баримт бичгийн тоо	Тоо	0	<b>Эхний хагас жилд: Боловсруулалт 60%. Жилийн эцэст: 1</b>	“Мирим” ХХК стратегийн төслийг боловсруулан ИНҮТ-ийн даргын 2021 оны А/37 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Тус баримт бичгийн төслийг ИНҮТ-ийн холбогдох газар, алба,	70%	АННББЗГ ИНҮТ

								нэгжүүдэд танилцуулж, хэлэлцүүлэг хийж, саналыг төсөлд тусгасан.		
19	5.3.	“Буянт-Ухаа” ОУНБ-ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулна.		Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Хувь	75%	<b>Эхний хагас жилд: 100%</b>	Зам, тээврийн хөгжлийн сайд шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2021 оны 4 дүгээр сарын 19-нд баталж, бүрэн хэрэгжүүлсэн. ИНЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/61 дугаар тушаалаар “Буянт-Ухаа” ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, шилжүүлэх бэлтгэлийг бүрэн хангасан.	100%	АННББЗГ ИНУТ
20	5.4.	“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг ашиглах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.		Төлөвлөгөөнд тусгагдсан 2021 онд хийх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	Хувь	79%	<b>Жилийн эцэст: 100%</b>	“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг ашиглах төлөвлөгөө”-г ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч 2021.09.28-ны өдөр баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 2021 онд хэрэгжүүлэх 67 ажил 2021.12.01-ний өдрийн байдлаар 96 %-тай байна.	90%	ИНУТ
21	5.5.	Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудлыг олон улсын болгох судалгаа, эдийн засгийн дүн шинжилгээ хийж, тайланг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлнэ.		Судалгааны тоо	Тоо	0	<b>Эхний хагас жилд: 1</b>	Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудлыг олон улсын болгох талаарх судалгаа, эдийн засаг үр ашгийн тооцоог хийж, 2021 оны 11 дүгээр сарын 17-ны 01/1987 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.	100%	АННББЗГ
22	5.6.	Орон нутгийн зорчигч тээврийн автобуудал, нисэх буудал, төмөр замын		Зохих тооцоо судалгааг хийсэн эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд: 1</b>	Орон нутгийн зорчигч тээврийн автобуудал, нисэх буудал, төмөр замын үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг	100%	АННББЗГ

		үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийж, ЗТХЯ-нд хүргүүлнэ.						дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийж, 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын даргад биечлэн танилцуулсан. 2021.07.27-ны 01/12111 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.		
23	5.7.	“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангана.		Хэрэгжилт, хувиар	Хувь	30%	<b>Жилийн эцэст:</b> 40%	Хөтөлбөрийн хэрэгжилт энэ оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 78.8%-тай байна.	100%	ИНҮТ ЕЗНА
	6.	<b>Зорилт 6</b> <b>Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн Хавсралтууд, стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцүүлэх</b>		Батлагдсан дүрмийн тоо  Конвенцид нэгдэн орох бэлтгэл хангалт	<b>Тоо</b>  <b>Хувь</b>	<b>35</b>  <b>0</b>	<b>Эхний хагас жилд:</b> 48  100%	<b>Эхний хагас жилд-48</b>		
24	6.1.	Иргэний нисэхийн багц дүрмийг батлуулна.		Батлагдсан дүрмийн тоо	Тоо	35	<b>Эхний хагас жилд:</b> 48	13 ИНД (91, 115,121, 125, 119,133, 135, 137,171,172,173,174,175) дүрмийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.02.04-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулж, Улсын нэгдсэн бүртгэлийн 4414 дугаарт нэмж бүртгүүлсэн. Одоогийн байдлаар Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны 48 дүрэмтэй болсон.	100%	ХЭЗДБГ
25	6.2.	Чикагогийн конвенцийн 50 дугаар зүйлийн 50		Хуулийн төслийг боловсруулах	Хувь	0	<b>Эхний хагас жилд:</b> 100%	Чикагогийн конвенцийн 50 дугаар зүйлийн 50 (а) хэсэгт өөрчлөлт оруулсан 2016 оны	100%	АТБЗГ

		(а) хэсэгт өөрчлөлт оруулсан 2016 оны Протокол, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн 56 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан 2016 оны Протоколд тус тус нэгдэн орох бэлтгэлийг хангана.		бэлтгэл ажлын гүйцэтгэл, хувиар				Протокол, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн 56 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан 2016 оны Протоколд тус тус нэгдэн орох бэлтгэлийг ханган, Протоколуудын орчуулга, нэгдэн орох хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг боловсруулан ИНЕГ-ын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 01/779 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Тус асуудлыг ЗТХС-ын зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 19 дүгээр хуралдаанаар хэлэлцэн ЗГХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцийн 56 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан 2016 оны протоколд нэгдэх тухай" хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулгыг дахин хянаж, УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, энэ оны 9 дүгээр сарын 09-нд ЗТХЯ-ны ИНБХЗГ-т цахимаар хүргүүлсэн.		
26	6.3.	Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт иргэний нисэхийг хөгжүүлэх чиглэлээр тусгах санал боловсруулна.		Хөгжлийн бодлого боловсруулах ажлын үе шат	Үе шат	1	<b>Эхний хагас жилд: 7</b>	ЗГХЭГ-ын даргын 2021.07.24-ний өдрийн 50 дугаар тушаалаар Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг, Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот	70%	АННББЗГ

								хөтөлбөр боловсруулах дэд ажлын хэсэг тус тус байгуулагдсан бөгөөд 2022 оны 3 дугаар сард багтаан хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах юм. Дэд ажлын хэсгээс өгсөн чиглэлийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, хөтөлбөрийн төсөлд тусгах саналаа ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газарт 2021.10.05-нд хүргүүлж, 2021.10.08-нд биечлэн танилцуулсан. Тус газраас өгсөн саналын дагуу дахин шинэчлэн боловсруулж, 2021.10.14-ний өдөр ЗТХЯ-нд цахимаар хүргүүлсэн. Дараагийн үе шатны ажлууд дэд ажлын хэсгээс өгсөн чиглэлийн дагуу хийгдэнэ. Тус байгууллага 5 үе шатны ажлыг хийсэн.		
27	6.4.	Аэродромын шувуу, мал, амьтдыг хянах үйл ажиллагааны стандарт боловсруулж батлуулна.		Батлуулсан стандартын тоо	Тоо	0	<b>Эхний хагас жилд:</b> Боловсруулалт 70% <b>Жилийн эцэст:</b> 1	СХЗГ-ын Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хорооны 2021.11.25-ны өдрийн хурлаар стандартын төслийг хэлэлцэж, батлах шийдвэр гарсан. Шийдвэр 12 сард албажина.	100%	АННБЗГ ИНҮТ
28	6.5.	Агаарын хөлгийн шатахууны чанар, үйл ажиллагааны JIG-2 стандартыг боловсруулж батлуулна.		Батлуулсан стандартын тоо	Тоо	0	<b>Эхний хагас жилд:</b> Боловсруулалт 100% <b>Жилийн эцэст:</b> 1	СХЗГ-ын Иргэний нисэхийн стандартчиллын техникийн хорооны 2021.10.20-нд болсон хурлаар стандартын төслийг хэлэлцэж, батлах шийдвэр гарсан. Шийдвэр 12 сард албажина.	100%	АННБЗГ ИНҮТ



	7.	<b>Зорилт 7</b> Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн хавсралт 19-ийн хэрэгжилтийг хангах		Чикагогийн конвенцийн хавсралт 19-ын 3 дугаар бүлгийн хэрэгжилт, хувиар	Тоо	50%	Жилийн эцэст: 60%	Чикагогийн конвенцийн хавсралт 19-ын 3 дугаар бүлгийн хэрэгжилт-45%		
29	7.1.	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.		Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	Хувь	35%	Жилийн эцэст: 50%	ИНЕГ-ын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан ИНЕГ-ын даргын 2020 оны А/282 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг 2020 оны 6 дугаар сарын 29-нд ИНЕГ-ын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан 36 арга хэмжээг 2022 онд багтаан хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Нарийвчилсан төлөвлөгөө 2021 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар 55%-ийн хэрэгжилттэй, хөтөлбөрийн хэрэгжилт 45%-байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгжилт 10%-иар өссөн дүнтэй байна. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах төслийг боловсруулсан боловч, батлагдаагүй. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2021 онд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:	100%	НААХЗА

							<p>1. ОУИНБ-аас гаргасан стандарт асуумжийн хүрээнд зөрүүтэй байдлын үнэлгээ, дүн шинжилгээ /SSP GAP analyse/ хийсэн. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог баталгаажуулж буй арга хэлбэр, хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх үүднээс 16 асуулга бүхий асуултыг тавихад Агаарын тээвэрлэгч болон гэрчилгээ эзэмшигч байгууллагуудын хүрээнд 60-70% хангаж ажиллаж байгааг тодорхойлсон. НААХЗА-ны Хэлтсүүдийн үйл ажиллагааны заавраас бусад үйл ажиллагаанд ашиглаж буй баримт бичгийн хүрээнд судалгаа хийж “НААХЗА-ны үйл ажиллагааны ерөнхий журам” боловсруулсан, батлагдах шатандаа явж байна. НААХЗА-ны хяналт шалгалтаас гадна аль нэг үйлчилгээ эрхлэгч байгууллага өөрийн ААУТ-оо үнэлэх, зөрүүтэй байдлаа тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, Гүйцэтгэлд суурилсан хяналт шалгалтын арга барилыг хөгжүүлэх, Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн байдлыг үнэлэх, аюулгүй ажиллагааны эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд бодит үнэлгээ дүгнэлт өгөхөд дэмжлэг болох Safety management International Collaboration Group-SM ICG -</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

							<p>ээс бэлтгэсэн "Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд үнэлгээ хийх аргачлал"-ыг Монгол хэлэнд орчуулан боловсруулж, үйл ажиллагаанд ашиглаж байна. ИНД-12 "Мэдээлэл дамжуулах журам"-ын хүрээнд сүүлийн 6 жилийн хугацаанд мэдээлэгдсэн аюулгүй ажиллагааны өгөгдлийн санг ашиглан НААХЗА-ны хэлтэс бүрт хамаарах аюулгүй ажиллагааны эрсдлийг ангилж гаргасан. Өгөгдлийг Осол /Accident, Ноцтой зөрчил /Serious incident/, Incident /зөрчил/ ,Аюулгүй ажиллагаанд нөлөөлөөгүй тохиолдол /Occurrence without safety effect/ гэсэн 4 үндсэн байдлаар ангилсан. Үнэлгээнд үндэслэн НААХЗА-аас хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг гаргасан. Агаарын тээвэрлэгч, агаарын навигацийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 18 байгууллагад Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн, газар дээр нь зөвлөмж хүргүүлсэн. Аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийг хянах журмын төслийг боловсруулсан. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Аюулгүй ажиллагааны удирдлага, хяналт зохицуулалт хийж буй</p>	
--	--	--	--	--	--	--	---	--

								байгууллагын санхүүгийн чадавхи, хяналт шалгалт хийж буй ажилтнуудын мэдлэг, дадлага, туршлага, ур чадвар, чадавхитай холбоотой саналыг тусгуулсан. Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах үүднээс Зөвшөөрлийн тухай, Зөрчлийн тухай, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох саналуудыг /38, 64, 120 санал/ тус тус боловсруулж хүргүүлсэн.		
	8.	<b>Зорилт 8 Агаарын навигацийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</b>	<b>Агаарын навигацийн үйлчилгээг сэргээх арга хэмжээ авсан эсэх</b>	<b>Тийм-1 Үгүй-0</b>	<b>0</b>	<b>Жилийн эцэст: 1</b>				
30	8.1.	Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийг ашиглалтад оруулна.	Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар	Хувь	90%	<b>Жилийн эцэст: 100%</b>	ИНЕГ-аас өмнөх гэрээг дүгнэж цаашид гэрээ байгуулах буюу цуцлах асуудлыг шийдвэрлүүлэх, ажлыг эрчимжүүлэх ажлын хэсгийг 2020.12.17-ны өдрийн ИНЕГ-ын даргын А/747 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсгийн өгсөн чиглэлийн дагуу “Үүрэг трейд” ХХК-ийн инженерүүдтэй хамтран үлдэгдэл ажлын тоо хэмжээ, түүнийг хийж гүйцэтгэх зардлын тооцоог 2021 оны 2 дугаар сарын 03-нд гаргасан. Гүйцэтгэгч компани шаардлагатай нэмэлт санхүүжилт болох 2,199 тэрбум төгрөгийн нэмэлт гэрээ	0%	Ажлын хэсэг	

								байгуулсан тохиолдолд барилгыг 2021.05-ны өдрийн дотор багтаан ашиглалтад оруулах боломжтой, нэмэлт гэрээ байгуулаагүй тохиолдолд барилгын ажлыг дуусгах боломжгүй талаар мэдэгдсэн. ИНЕГ-аас “Үүрэг трейд” ХХК-ийг “Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-ний үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй үнийн дүнгийн алданги болох 664,161,009.00 /Зургаан зуун жаран дөрвөн сая, нэг зуун жаран нэгэн мянга есөн/ төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан боловч харьяаллын дагуу Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. Шүүх хурал 2021.06.02-ны өдөр хуралдахаар зарлагдсан байсан боловч 2021.06.17-ны өдөр хүртэл хойшилсон. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан шүүх хурал тодорхойгүй хугацаагаар дахин хойшлогдсон. ИНЕГ-аас шүүхээр шийдвэрлүүлэх нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэн шүүхэд холбогдох материалыг 2021.08.04-ний өдөр хүргүүлж, уг өдөр шүүх хуралдсан боловч хариуцагч тал шүүгчээс татгалзах хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч		
--	--	--	--	--	--	--	--	---	--	--

							<p>хуралдаан дахин хойшилсон. Хариуцагч талаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэх шүүх хурал 2021.09.02-ны өдөр зарлагдаж, хариуцагч талаас эвлэрэлийг дэмжсэн, ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай санал тусгасан хурлын тэмдэглэл буюу нэмэлт материал шүүхээр гаргуулахаар хүсэлт гаргаж, шүүгчийн захирамжаар 2021.09.23-ны өдөр хүртэл хойшлогдсон. Ажлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргуулах хүсэлтээ Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. ЗТХЯ-наас барилгын ажил олон жил дамнан удааширч, төсөвт өртөг нэмэгдэж буй асуудалтай холбогдуулан барилгыг яаралтай ашиглалтад оруулах талаар мэргэжил арга зүйн дэмжлэг, санал зөвлөмж авах хүсэлтийг БХБЯ-нд хүргүүлсэн. БХБЯ-наас ажилд дахин магадлал хийх үндэслэлгүй тул барилга угсралтын ажилд тавих хяналтыг сайжруулж, гэрээт ажлыг дуусгах, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцалж алданги, хохирол нэхэмжлэх, Сангийн яамны хар жагсаалтад оруулах асуудлыг шийдвэрлүүлэх чиглэл өгсөн болно. ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021.09.09-ны өдрийн А/113 дугаар тушаалаар Бүсийн нислэгийн</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

								хөдөлгөөний удирдлагын төвийн барилгыг 2021 онд ашиглалтад оруулах зорилгоор гүйцэтгэгчтэй хэлцэл хийх ажлын хэсгийг томилсон. БГД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021.09.23-ны өдрийн 102/ШЗ2021/11677 дугаар захирамжаар хийсэн болон цаашид хийх ажлын тоо хэмжээ, зардлын тооцоог гаргах, дүгнэлт гаргуулах хөндлөнгийн шинжээчийг томилуулсан. 2021.10.25-ны өдрийн 102/ШЗ2021/13318 дугаар захирамжаар өмнөх шийдвэрт өөрчлөлт оруулж, энэ оны 12 дугаар сарын 25-ны дотор үр дүнг танилцуулахыг “Хөрөнгийн үндэсний төв” ХХК-д даалгасны дагуу холбогдох мэдээллийг ИНЕГ-ын 2021.11.17-ны өдрийн 06/1985 тоот албан бичгээр тус төвд хүргүүлсэн. Хэргийг түр түдгэлзүүлээд байна.		
31	8.2.	Монгол Улсын агаарын зайд дамжин өнгөрч байгаа БНХАУ-ын орон нутгийн нислэгийн тоог нэмэгдүүлэх талаар судалгаа хийнэ.		Зохих тооцоо судалгааг хийсэн эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд: 1</b>	Монгол Улсын агаарын зайд дамжин өнгөрч байгаа БНХАУ-ын орон нутгийн нислэгийн тоог нэмэгдүүлэх талаар БНХАУ-ын орон нутгийн нислэгийн тоонд тулгуурлан судалж, Монгол Улсын агаарын орон зайд ямар чиглэлээр агаарын зам шинээр татах тухай судалгааг хийсэн.	100%	АННББЗГ
32	8.3.	Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази номхон далайн		Зохих тооцоо судалгааг хийж, сэргээх төлөвлөгөө	Тийм-1 Үгүй-0	0	<b>Эхний хагас жилд: 1</b> <b>Жилийн эцэст:</b>	“COVID-19 цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдлын дараа агаарын навигацийн үйлчилгээг сэргээх ерөнхий	100%	АННББЗГ ИНҮТ

		орнуудын бүсийн төвөөс зохион байгуулсан ACCRPG ажлын хэсгээс гарсан зөвлөмжийн хүрээнд агаарын навигацийн үйлчилгээг сэргээх төлөвлөгөөний төслийг боловсруулж танилцуулна.		боловсруулсан эсэх			1	төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, танилцуулсан.		
33	8.4.	Бүсийн нислэгийн үйлчилгээний нөөц төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийнэ.		Нөөц төлөвлөгөөг судалж, санал дүгнэлтээ танилцуулсан эсэх	Тийм-1 Үгүй-0	0	<b>Жилийн эцэст:</b> 1	ИНУТ-ийн даргын 2021 оны 5 дугаар сарын 27-ны А/186 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Улаанбаатар нислэгийн мэдээллийн районы нислэгийн хөдөлгөөний менежментийн нөөц төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж, нөөц төлөвлөгөөг англи хэл дээр боловсруулж, АННББЗГ-т хүргүүлсэн. Албан ёсны орчуулгыг "МОН" ХХК-аар гүйцэтгүүлж байна.	100%	ИНУТ
34	8.5.	Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй өнгөрөлтийн болон нисэх буудлуудад хөөрч, бууж буй агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлнэ.		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо  Орон нутгийн нислэгийн тоо	Тоо	0	<b>2021 онд:</b> Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо-71756 Орон нутгийн нислэгийн тоо-5755 <b>Эхний хагас жилд:</b> 32768; 2283 <b>Жилийн эцэст:</b> 38987 ; 3472	Монгол Улсын агаарын зайд 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар Монгол Улсын агаарын зайд 66564 нислэг гүйцэтгэгдсэн байна. Үүнд: Олон улсын өнгөрөлтийн нислэг - 60382, Олон улсын буулт, хөөрөлт- 2021, Орон нутгийн нислэг - 4161 байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Олон улсын өнгөрөлтийн нислэг- 6.4%-иар, орон нутгийн нислэг- 23.1% -иар тус тус буурсан, олон улсын буулт, хөөрөлт- 27.3%-иар өссөн дүнтэй байна.	100%	ИНУТ



								Цар тахлын улмаас өнгөрөлтийн нислэг багасч, төлөвлөсөн түвшинд хүрээгүй.		
	9.	<b>Зорилт 9 Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах</b>		Чикагогийн конвенцийн хавсралт 9, 14, 19-ийн шаардлагыг хангуулж, үндэсний баримт бичигт өөрчлөлт оруулсан эсэх	<b>Тийм-1 Үгүй-0</b>	<b>0</b>	<b>Жилийн эцэст:</b> 1; 1	Өөрчлөлт оруулсан баримт бичиг-2		
35	9.1.	“Иргэний нисэхийн аюулгүй байдлын Үндэсний хөтөлбөр”, “Агаарын тээврийн хялбаршуулах Үндэсний хөтөлбөр” болон “Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангана.		Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь  Зөвлөлүүдийн батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хувь	0	<b>Жилийн эцэст:</b> 100%, 100%; 100%;  80%	Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийг шинэчлэн Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн Агаарын тээврийг хялбаршуулах журам болгож, Засгийн газрын 2021 оны 136, 137 дугаар тогтоолоор батлуулсан. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэ оны 5 дугаар сарын 04-ний өдөр ЗТХС-аар батлуулж, гишүүдэд цахимаар хүргүүлэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг мэдэгдсэн. Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 92%-тай байна. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 8 дугаар хурлыг 2021.08.17-ны	100%	АННББЗГ ИНҮТ

							<p>өдөр зохион байгуулсан. Хурлаас 4 шийдвэр гарсан ба шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ЗТХСайдаар батлуулсан. Шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2021 оны жилийн эцсийн байдлаар 97.5%-тай. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх нарийн бичгийн даргын ажлын албаны хурал"-ыг 2021 оны 11 дүгээр сарын 15 ны өдөр зохион байгуулсан. Агаарын тээврийг хялбаршуулах журмын шинэчилсэн найруулга Засгийн газрын 2021.05.12-ны хурлаар хэлэлцэгдэн 137 дугаар тогтоолоор батлагдсан. Зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэ оны 5 дугаар сарын 04-ний өдөр ЗТХС-аар батлуулж, гишүүдэд цахимаар хүргүүлэн, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хамтран хэрэгжүүлж, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнахыг мэдэгдсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай. Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 8 дугаар хурлыг 2021.08.17-ны өдөр зохион байгуулсан. Хурлаас 4 шийдвэр гарсан ба шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗТХСайдаар батлуулсан. Шийдвэрийг хэрэгжүүлэх арга</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

